



НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 1354

Улаанбаатар хот

Хариуцлагатай эргүүл, жижүүр  
томилох тухай

Өвөл цагийн горимд шилжсэнтэй холбогдуулан амралт, баяр ёслолын өдрүүдэд нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн хэвийн, жигд, найдвартай ажиллагааг хангах, байруудын дотоод журмын хэрэгжилтэнд тавих хяналтыг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн засаг захиргааны байруудад амралт, баяр ёслолын өдрүүдэд хариуцлагатай эргүүлээр ажиллах албан хаагчдын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн засаг захиргааны байруудын цахилгаан, дулаан, усан хангамжийн хэвийн жигд ажиллагааг хангаж, гал усны гамшгийн аюулаас урьдчилан сэргийлж, харуул хамгаалалтын ажилтнуудтай хамтран ажиллаж, гарсан зөрчил, доголдлыг шуурхай барагдуулан, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллахыг хариуцлагатай эргүүлээр ажиллах албан хаагчдад даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн талаар газрын удирдлагад танилцуулж ажиллахыг Инженер техникийн албаны дарга /М.Мөнхсүрэн/-д даалгасугай.

ДАРГА  ШОДОНЧИМЭГ



1157700711